



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/554

Улаанбаатар хот

Г Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн Г
газрын эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 11,454,100 /арван нэгэн сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга нэг зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар /С.Нямдорж/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгөнөөс 1 нэр төрлийн 5,000,000 /таван сая/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 12 нэр төрлийн 6,454,100 /зургаан сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга нэг зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн газар /С.Нямдорж/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115060001375

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 08 ны өдрийн 0/571 тоот тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан			Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	Мэргэж илтний санал	ЭБХХК-ийн хурлын шийдвэр
		Ажил	Хажигч	Хэмжээ									
Бусад биет хөрөнгө													
1	Хор цацагч	2	ш	10	180 000.00	1 800 000.00	825 000.00	975 000.00	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
Бусад биет хөрөнгийн дүн						1 800 000.00	825 000.00	975 000.00					
Машин, тоног төхөөрөмж													
1	Принтер hp1102	8	ш	1	200 000.00	200 000.00	200 000.00	200 000.00	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн						200 000.00	200 000.00	-					
Тавилга, эд хогшил													
1	Сейф физиол	12	ш	1	250 000.00	250 000.00	250 000.00	250 000.00	Эвдэрсэн	актлах	устгах	татах	татах
2	Хурлын ширээ 380	11	ш	1	380 000.00	380 000.00	380 000.00	380 000.00	Эвдэрсэн	актлах	устгах	татах	татах
3	Дарга ширээ 400	11	ш	1	400 000.00	400 000.00	400 000.00	400 000.00	Эвдэрсэн	актлах	устгах	татах	татах
4	Сэтгүүлийн ширээ 70	11	ш	1	70 000.00	70 000.00	70 000.00	70 000.00	Эвдэрсэн	актлах	устгах	татах	татах
5	Сандал 35	11	ш	3	35 000.00	105 000.00	105 000.00	105 000.00	Эвдэрсэн	актлах	устгах	татах	татах
6	Сургалтын сандал 40,0	8	ш	10	40 000.00	400 000.00	326 666.58	73 333.42	Эвдэрсэн	актлах	устгах	татах	татах
7	Сандал II2349	8	ш	1	159 500.00	159 500.00	147 537.5	11 962.46	Эвдэрсэн	актлах	устгах	татах	татах
8	Сандал 5193	7	ш	1	400 000.00	400 000.00	263 333.1	136 666.93	Эвдэрсэн	актлах	устгах	татах	татах
9	Сургалтын ширээ 15,0	8	ш	10	150 000.00	1 500 000.00	1 225 000.00	275 000.00	Эвдэрсэн	актлах	устгах	татах	татах
10	Зөвлөгөөний ширээ / дүгүй булант /	10	ш	1	789 600.00	789 600.00	789 600.00	-	Эвдэрсэн	актлах	устгах	татах	татах
Тавилга, эд хогшлын дүн						4 454 100.00	3 957 137.2	496 962.8					
Программ хангамж													
1	Веб хуудас	6	ш	1	5 000 000	5 000 000.00	5 000 000.00	-	Ашиглалтаас гарсан	актлах	устгах	устгах	устгах
Программ хангамжийн дүн						5 000 000.00	5 000 000.00	-					
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						11 454 100.00	9 982 137.19	1 471 962.81					
Үүнээс Татан төвлөрүүлэх хөрөнгө						6 454 100	4 982 137	1 471 963					
Актлах хөрөнгө						5 000 000	5 000 000	-					